



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН  
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах  
тухай

Монгол Улсын "Төрийн албаны тухай хууль"-ийн 26.1.1 дэхь заалт, "Хөдөлмөрийн хуулийн" 5.1, 13<sup>1</sup>.1.1 дэхь заалт байгууллагын "Дотоод журам"-ын сахилга хариуцлагын аравдугаар бүлгийн 10.4.1 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Хариуцсан ажилдаа алдаа гаргаж дээд шатны байгууллагуудад явуулсан мэдээ мэдээлэл тоо баримтад хяналт тавих ажилдаа хариуцлагагүй хандсан Дэд дарга Ч.Батсайхан, ахлах мэргэжилтэн Ц.Цолмон нарт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

Хоёр. Ажилтнуудад боловсруулж байгаа мэдээ мэдээлэл бичиг баримтдаа анхаарч, хариуцлагатай хандаж, дахин алдаа гаргахгүй байж, төрийн албан хаагчидын ёс зүйг сахиж ажиллахыг анхааруулсугай.

ДАРГА  Д.МӨНХЦОГ

